

# Living the Lotus 11

Buddhism in Everyday Life

2024  
VOL. 230



**РКК, Сан-Франциско салбарын 45 жилийн ойн баяр  
2024.09.15**



## Living the Lotus Vol. 230 (2024.11)

Ахлах редактор: Акагава Кэйичи  
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ  
Эхийг хянасан: Ш.Зоригмаа  
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс  
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,  
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan  
TEL: +81-3-5341-1124  
FAX: +81-3-5341-1224  
Email: living.the.lotus.rk-international@  
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*



## Учрал нь хүндлэх ба ичих сэтгэлийг хөгжүүлдэг - 1

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### Хүндлэх сэтгэлээ хөгжүүлэх нь

Өнгөрсөн жилийн өдийд би “Хүн өсөж хөгжихөд хүндлэх сэтгэлээ хөгжүүлж, ичихийг мэдэх хамгийн чухал.” (Ясүока Масахиро) хэмээх үгийг иш татан байгууллагын энэ жилийн зорилтыг тодорхойлж байсан. Аугаа гайхамшигт оршихуйтай ойртох юмсан гэх сэтгэл нь сүсэг бишрэлт хүмүүн төдийгүй хэн бүхэнд байх чухал бөгөөд хүн хүнээ хүндлэх нь сайн сайхан нийгмийг бүтээх үндэс суурь болохоор би тийнхүү тодорхойлсон билээ.

Гэхдээ өөрийгөө хүндэлдэггүй хүн бусдыг хүндлэх боломжгүй гэдэг гэж би давхар хэлсэн. Би хэдийгээр ингэж хэлж байгаа ч, надаас та өөрийгөө хүндэлж чадаж байгаа юу гээд асуувал шулуухан хэлэхэд тэр их хэцүү гэж хариулах байсан болов уу.

Хэдий тийм ч гэсэн өөдөөс минь алга хавсран мөргөх гэрийнхээ Бурханы ачаар би өөрийнхөө эрхэм нандин оршихуй болохыг ойлгож ухамсарладаг. Үүнийг ч гэсэн би хэд хэдэн удаа хэлж байсан. Мөн ингэж хэлэхэд санаа зовмоор ч гэсэн би өглөө, орой Бурхандаа мөргөхдөө “Бурхан надад ч гэсэн мөргөж байна” гэж сэтгэлдээ эргэцүүлэн боддог юм.

Энэ жилийн зорилт ханз үсгийг “эмээх ба хүндлэх” гэж тодорхойлсон нь ч гэсэн мэдээж хэрэг хүндлэн бишрэх сэтгэлийн чухлыг дамжуулахыг хүссэн болохоор тэр. Эмээх, хүндлэн бишрэх гэхээр бурхан сахиулсан, сансар огторгуй, өргөн уудам байгаль дэлхий зэрэг хүний мэдлэг чадварыг хол давсан оршихуй хийгээд дэлхий ертөнц хууль төсөөлөгдөнө. Гэгээнтэн, мэргэд, аугаа хүмүүн зэрэг түүхэн хүмүүсийг хүндлэн дээдлэх сэтгэл ч гэсэн үүнд багтана. Гэхдээ нөгөөтэйгүүр өдөр бүр учрах хүмүүс, үйл явдал зэрэг эргэн тойронд болох “учрал” бүр хүндлэн дээдлэх зүйл мөн бөгөөд хүндлэх сэтгэл нь өдөр тутмын амьдралд илүү хөгждөг гэж би боддог.



## Учрал бол сэтгэлийн амин дэм

Эцэг эх, хүүхэд дээр жишээ авбал эцэг эх нь нэг талыг барьсан үзэл баримтлалаар өөрсдийгөө зөвтгөн хүүхдээ загнаж зандрах нь их байдаг болохоор тэр үү эртний Хятадын сэтгэгч Мэнз “Номт хүмүүн хүүхэддээ заадаггүй” гэж хүртэл сургасан байдаг. Эндээс эцэг эх, хүүхдийн харилцаагаар хүндлэх сэтгэлийг хөгжүүлэх нь эртнээс хэцүү байсныг ойлгож болно. Би хувьдаа хэдий эцэг эх, хүүхэд ч гэсэн хүн бүр өөрийн гэсэн зан чанар, онцлогтой учраас түүнийгээ харилцан ойлгож мэдэрч, эцэг эх нь хүүхдийнхээ онцлог чанарыг хүндэлдэг байхад болно гэж боддог. Түүнчлэн эцэг эхийн үг хэл, үйл хөдлөл зөрөхгүй байхад анхаарууштай. Энэ бол эцэг эх, үр хүүхэд хамтдаа хүндлэн дээдлэх сэтгэлээ хөгжүүлэх арга зам юм.

Хүндлэх гэхээр бид өөрийн мэдэлгүй “дээд” зүйлийг төсөөлдөг. Гэвч өөртэй ижил түвшний хүн, өөрөөс нас залуу мэдлэг туршлага бага хүн ч гэсэн хүндлэх сэтгэлийг хөгжүүлэх чухал хүмүүс. Эхнэр нөхөр, найз нөхдийн хувьд ч гэсэн адилхан. Хамгийн чухал нь нөгөө хүнийхээ онцлог тал, зан чанарыг хүлээн зөвшөөрч, түүний сайн сайхан талыг мэдэрч, магтаж, түүнээс суралцах юм. Энэ нь өөрийн болон бусдын хүндлэх сэтгэлийг хөгжүүлдэг. Ингээд бодоод үзэхээр учрал бүхэн хүндлэх сэтгэлийг хөгжүүлэх амин дэм болох ба Насад зэвүүцэхгүй бодисадвагийн хүндлэн мөргөх үйлийг санагдуулна.

Бизнесийн бурхан гэгддэг Мацүшита Кооносүкэ гуай “Хүндлэх сэтгэлтэй байх аваас байгаль дэлхий, орчлон ертөнцөд хүндлэн дээдлэх зүйл бишгүй бий” гэж хэлдэг. Түүнчлэн “Хүнд аливаа юмс, хүмүүсийн эрхэм нандин үнэ цэнийг олж харах чадвар бий” гэж хэлээд тэр чадвараараа харилцан биенийхээ хүндлэх сэтгэлийг хөгжүүлцгээе гэж уриалдаг.

Гэхдээ “Хүндлэх сэтгэл хөгжөөд ирэхээр эсрэгээрээ өөрийнхөө сул доройг анзаарч, түүнээсээ ичих сэтгэл төрдөг.” (Ясүока Масахиро) гэж хэлдэг. Тэгэхээр учрал нь ичихийг мэдэх сэтгэл хэмээх бас нэг чухал сэтгэлийг хөгжүүлдэг гэсэн үг. Дараа сарын дугаарт гишүүд бидний хувьд чухал учралуудын нэг болох сургаал түгээх үйл хийгээд “ичих сэтгэл”-ийн талаар хамтдаа бодож үзэх болно.

“Косей” сэтгүүл, 11-р сарын дугаараас





# Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

## Нийгэмлэгийн тэмдэглэлт баяр ёслолууд

### Байгууллагын ойн баяр

3-р сарын 5 бол Рисшо Косей Кай нийгэмлэг байгуулагдсан ойн баярын өдөр.

1938 оны энэ өдөр тус нийгэмлэг Цагаан лянхуа судрын сургаалд тулгуурлан хүмүүсийг аварч, аз жаргалтай болгохыг зорин үүсгэн байгуулагдсан билээ.

Байгуулагдах үедээ 30 хүрэхгүй гишүүдтэй байсан боловч одоо гадаадад ч гишүүдтэй

шашны томоохон байгууллага болжээ. Гишүүд сургаал номд суралцаж, аз жаргалыг олж, тэрхүү баяр баясгалангаа олон хүнд түгээсэн учраас ийнхүү өргөжин тэлсэн юм.

Энэ өдөр Их Ариун Ордон, улс даяарх салбар нийгэмлэгүүдэд байгууллага үүсэн байгуулагдсаны утга учрыг тунгаан бодож, сургаалыг түгээн дэлгэрүүлэхээ дахин тангарагладаг.



\* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.





## Залуучуудын өдөр



### Бяцхан мэдлэг

“Залуучуудын өдөр”-ийн үйл ажиллагаа нь 1970 оны 5 сард анх “Үндэсний залуусын бүлгэмийн мужуудын нэгдсэн үйл ажиллагаа” нэрийн дор явагдаж эхэлсэн.

“Гэрэлт нийгмийг цогцлоох нь бидний гарт” гэсэн уриатайгаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын аян, цус хандивлах аян, сайн дурын цэвэрлэгээний ажлуудыг зохион байгуулдаг байжээ.



Рисшо Косей Кай нийгэмлэг нь залуусын бүлэгтэй бөгөөд үүнд бага ангийн багачуудын бүлэг, дунд, ахлах ангийн сурагчдын бүлэг багтдаг. “Залуусын өдөр”-ийг жил бүрийн 5-р сарын гурав дахь долоо хоногийн ням гарагт бүх салбар зохион байгуулдаг.

Энэ өдөр салбар бүр орон нутгийнхаа иргэдийн хүсэлтээр сайн дурын цэвэрлэгээний ажил, нийгмийн халамжийн байгууллагууд дахь өндөр настнуудтай халуун дотноор харилцах, хүмүүсийг энхтайван, байгаль орчны асуудлуудыг шийдэхэд уриалах, чөлөөт худалдааны зах ажиллуулах, ЮНИСЕФ (Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сан)-т зориулж гудамжинд хандив цуглуулах зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг.

Мөн өдрийн 12 цагт 1 минутын турш бүх салбар “Энх тайвны төлөөх залбирал”-ыг үйлддэг.

\* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



## Учрал бүрийг өөрийн багш гэж хүлээн авах

Акагава Кэйичи

Сайн байцгаана уу? Японд намрын улирал улам бүр өнгө нэмж хаа сайгүй алтан шаргал навчсыг харж таашаах үе ирлээ. Уншигч та бүхэн арваннэгдүгээр сарыг хэрхэн өнгөрөөж байна вэ?

Нивано ерөнхийлөгч энэ сарын айлдвартаа энэ жилийн нийгэмлэгийн зорилтыг дурьдангаа “хүндлэх сэтгэл” ба “ичих сэтгэл”-тэй байхын ач холбогдлыг таниулж, мөн учрал тохиол болгон хүндлэх сэтгэлийг хөгжүүлэх амин дэм болдгийг сургасан. Хэн нэгэнтэй уулзах учралыг хэрхэн хүлээж авах нь тухайн хүн, нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байдаг. Тийм ч учраас сүсэгтэн, бурхны зам мөрийг эрэлхийлэгч бид ямар зүрх сэтгэлтэй байх нь чухал. Учралд хувиа хичээсэн сэтгэлээр хандах уу, даруу төлөв талархлын сэтгэлээр хандах уу гэдгээс шалтгаалж харилцан адилгүй үр дүн гарна гэдгийг таамаглахад тийм ч хэцүү биш.

Би сар бүр айлдварыг унших болгондоо Нивано ерөнхийлөгчийн 40-өөд жилийн өмнө бичсэн «Бүх зүйл миний багш» гэдэг номыг санадаг. Тэрхүү номонд сургаал номыг залгамжлан авахаас өмнөх ерөнхийлөгчийн сэтгэл санаа хийгээд учрал болгоныг багшаа гэж үздэг шашин шүтлэгт хүний гол хандлагыг дүрсэлсэн байдаг.

Намрын налгар амралтын өдрүүдээр энэхүү гайхалтай номыг дахин гартаа барьж эргэцүүлэн уншъя гэж бодож байна.

Мөн энэ сарын айлдварт сургасны дагуу учрал бүрийг “хүндлэх сэтгэлийг төлөвшүүлэх амин дэм” гэж хүлээн авч Насад зэвүүцэхгүй бодьсатвагийн үйлийг хэрэгжүүлэх болно.



Удирдах төвийн Фүмон Медиа төвд зохион байгуулагдсан Гол шүтээнийг залах ёслол. Хойд Америкийн сургаал дэлгэрүүлэх төвийн дарга Ёшизава (баруун дээд талд), Колката салбарын ахлагч Барүа (зүүн доод талд) нар Акагава хэлтсийн даргаас Гол шүтээнийг хүлээн авч байгаа нь.




# Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



## 🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about  
local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)